




ТАВАНТОЛГОЙ-ГАСHUУНСУХАЙТ ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМЫН ЦОГЦОЛБОР ТӨСӨЛ

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам нь Тавантолгой уурхайгаас Гашуунсухайт боомт хүртэл 233,6 км үргэлжилнэ. Төслийн хүрээнд Монгол Улсад анх удаа 1 дүгээр зэрэглэлийн, уулзваргүй, хүнд даацын, жилд 30 сая.тн нүүрс тээвэрлэх хүчин чадалтай төмөр замыг бүтээн байгуулж, дохиолол холбоо, хориглолын систем, зам төмрийг уулзваргүй болгох гагнуурын технологи, хөдлөх бүрэлдэхүүн зэрэг төмөр замын бүтээн байгуулалтын чиглэл бүрд шинэ технологи, инновацыг нэвтрүүлснээрээ онцлог юм. Тус төмөр замын тээвэрлэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр эхлүүлж, 2023 оны 05 дугаар сард төслийн суурь бүтцийг байнгын ашиглалтад оруулсан.

ТАВАНТОЛГОЙ-ГАСHUУНСУХАЙТ ТӨМӨР ЗАМЫН БУДУУВЧ



ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Гол замын урт 233.6 км	Зэрэглэл I	Өртөө 2	Жилд тээвэрлэх ачааны хэмжээ 30 сая тонн
Зөрлөг 6	Төмөр замын голын даац 25 тонн	Царигийн хэмжээ 1520 мм	Хагас автомат хориглолын систем


ТАВАНТОЛГОЙ-ГАСHUУНСУХАЙТ, ТАВАНТОЛГОЙ-ЗҮҮНБЯАН ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМУУДЫГ ХОЛБОХ 21.9 КМ ТӨМӨР ЗАМ

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замыг Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 416.1 км төмөр замтай 21.9 км төмөр замаар холбосон. Ингэснээр Гашуунсухайт боомт Монгол Улсын төмөр замын нэгдсэн сүлжээнд холбогдож, ОХУ, БНХАУ-руу төмөр замаар тээвэрлэлт хийх боломж бүрдсэн төдийгүй Монгол Улс, БНХАУ-ын хооронд төмөр замын хоёрдахь гарцыг нээсэн юм. Холболтын төмөр зам ашиглалтад орсноор уурхайн бүтээгдэхүүнийг Хятадын Хуанхуа, Тяньжин, Чиндао, Жинжоу зэрэг далайн боомтод хүргэж, түүгээр дамжуулан гуравдагч орны зах зээлд борлуулах боломжтой болно.

Тавантолгойн нүүрс ачих логистикийн төв нь Тавантолгой нүүрсний ордоос олборлосон бүтээгдэхүүнийг Тавантолгой өртөөний дэргэдэх ачилтын тойрог замаас вагон болон чингэлэгт автомат удирдлагатай бункерын системээр хүлээн авч, бутлан тээвэрлэж, ангилан хольж, төмөр замын тээвэрт тасралтгүй ачих зориулалттай байгууламж юм.



ТЭЭВЭРЛЭЛТИЙН ҮЕИЙН АЧААНЫ ТОО ХЭМЖЭЭ



Эх сурвалж: "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 02 дугаар сарын 03 дугаар тогтоолоор батлагдсан "Төмөр замын тээврийн хөгжлийн хөтөлбөр-2050"

ШИЛЖҮҮЛЭН АЧИХ ТЕРМИНАЛ

Гашуунсухайт шилжүүлэн ачих терминал нь Тавантолгойн бүлэг ордоос төмөр замаар тээвэрлэсэн чингэлэгтэй ачааг вагоноос автомашинд, вагоноос вагонд шилжүүлэн ачих, талбайд хадгалах, экспортын тээвэртэй холбоотой бичиг баримтын бүрдүүлэлт, төлбөр тооцоог хийх нэг цэгийн үйлчилгээ, оффис зэрэг 24 цагийн тасралтгүй үйл ажиллагаатай байгууламж юм. Терминалын талбай нь бүхэлдээ гаалийн хяналтын бүс байх ба 167 ажлын байр шинээр бий болж, бүрэн ашиглалтад орсноор жилд 24.9 сая.тн ачааг шилжүүлэн ачих хүчин чадалтай.

ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮН

Зүтгүүр

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын гол шугамд АНУ-ын "Progress Rail" компанийн 5000тн жинтэй галт тэргийг татах 4500 морины хүч буюу 3355 кВт чадалтай, хувьсахаас хувьсах гүйдлийн AC-DC-AC цахилгаан дамжуулгын системтэй, олон улсын хүрээлэн буй орчны TIER2 стандартын шаардлагыг хангасан SD70Ace/LW серийн 16 илчит тэрэг, 2GS16C серийн сэлгээний 1 илчит тэргээр тээвэрлэлт хийнэ. Эдгээр зүтгүүрийн техник үйлчилгээ, их засварыг технологийн дагуу, иж бүрдлээр хийх депог АНУ-ын зүтгүүрийн депогийн төслийн дагуу барьж, 2024 онд ашиглалтад оруулна.



БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа 2050", Засгийн газрын "Шинэ сэргэлтийн бодлого", "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн 2021-2025 онд хэрэгжүүлэх "А6-20" бизнес төлөвлөгөө, олон улсын жишиг, онол арга зүйг үндэслэн компанийн урт хугацааны бодлогын баримт бичгийг боловсрууллаа.

Бид "Төслийн удирдлагын үйл ажиллагаа"-аас "Төмөр замын ашиглалт, тээвэрлэлтийн цогц үйлчилгээ" үзүүлдэг компани болж, өргөжин хөгжих зорилго тавин, үйл ажиллагаагаа төлөвлөн ажиллаж байна.

СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ 2050	ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР 2050	ХҮНИЙ НӨӨЦИЙН СТРАТЕГИ 2030
--------------------------	---	-----------------------------

Вагон

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замд тээвэрлэлт хийх 12-9853 төрлийн ачааны хагас вагон 400 ширхэг, 12-6724 төрлийн тавцант вагон 390 ширхэг, 11-6874 төрлийн битүү вагон 8 ширхэг, 13-6851-04 төрлийн тавцант вагон 13 ширхэг зэрэг ачааны нийт дөрвөн төрлийн 811 вагоныг ОХУ-ын Тихвины вагоны үйлдвэрээс, 1 ширхэг GCY 300 моторт вагоныг БНХАУ-аас Монгол Улсын хилээр тус тус хүлээн авч дууссан.



ГАСHUУНСУХАЙТ-ГАНЦМОД БООМТЫН ХИЛ ДАМНАСАН ТӨМӨР ЗАМ

Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнансан төмөр замын төслийн техник эдийн засгийн үндэслэл, иж бүрэн зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээг БНХАУ-ын "Төмөр замын зураг төслийн корпорац" ХХК /CRDC/ гүйцэтгэж байна. Уг ажлыг 2023 онд дуусгаж, 2024 оны I улиралд барилга угсралтын ажлыг эхлүүлэхээр төлөвлөж байна.

Гашуунсухайт-Ганцмод боомтыг төмөр замаар холбосноор жилд 30 сая.тн нүүрс тээвэрлэх хүчин чадалтай, Тавантолгойн бүлэг орд болон түүний ойр орчмын уурхайн эрдэс баялгийг тээвэрлэлтийн бага зардлаар БНХАУ-ын хэрэглэгчдэд хүргэх, цаашлаад БНХАУ-ын дэд бүтцийг ашиглан Зүүн Азийн бусад хэрэглэгчдэд хүргэх, бүс нутгийн байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, нутгийн иргэдийн амьдрах орчныг хадгалах зэрэг давуу талтай.



ОЛОН УЛСЫН СТАНДАРТ НЭВТРҮҮЛЖ БАЙНА

Богино хугацаанд компанийн засаглалыг бэхжүүлэн, үйл ажиллагаагаа дэлхийн жишигт нийцүүлэх зорилгоор олон улсын стандартуудыг нэгэн зэрэг нутагшуулж эхлээд байна.

Байгаль орчны менежментийн огтлолцоо ISO 14001	Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001	ХЭМАБ-ын менежментийн тогтолцоо ISO 45001	Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо ISO 27001	Төслийн менежментийн арга зүй ISO 21500
--	---------------------------------------	---	---	---

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ

Хувьцаа
ЭЗЭМШИГЧ



МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ

66%

34%



Тавантолгой Төмөр зам ХХК

Захиалагч

ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ ТӨСЛҮҮД

1

ТАВАНТОЛГОЙ-ГАШУУНСУХАЙТ ЧИГЛЭЛИЙН 233,6 КМ
ТӨМӨР ЗАМЫН ЦОГЦОЛБОР ТӨСӨЛ



2

ТАВАНТОЛГОЙ-ГАШУУНСУХАЙТ, ТАВАНТОЛГОЙ-
ЗҮҮНБАЯН ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМУУДЫГ ХОЛБОХ
21,9 КМ ТӨМӨР ЗАМ



3

ГАШУУНСУХАЙТ ШИЛЖҮҮЛЭН АЧИХ ТЕРМИНАЛ



4

ТАВАНТОЛГОЙН НҮҮРС АЧИХ ЛОГИСТИКИЙН ТӨВ




5

ГАШУУНСУХАЙТ-ГАНЦМОД БООМТЫН
ХИЛ ДАМНАСАН ТӨМӨР ЗАМ



НЭГДСЭН СҮЛЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ - 2020



ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ ХХК



QR кодыг уншуулж
дэлгэрэнгүй мэдээлэл
авна уу.

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
13-р хороолол 14230, Нарны зам-62
Юнион бюлдинг В блок 11 давхар
976 77777727
ttrailway@ttz.mn
www.ttz.mn



“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК

ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ ХХК

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТУЛГУУР,
ХӨГЖЛИЙН ЗҮТГҮҮР

КОМПАНИЙН ТУХАЙ

“Тавантолгой төмөр зам” ХХК нь 2018 оны 08 дугаар сарын 08-ны өдөр үүсгэн байгуулагдаж, төмөр замын суурь бүтэц барих, ашиглах, тээвэрлэх, суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн засварлах зэрэг үндсэн чиглэлээр цогц үйл ажиллагаа явуулж буй Монгол Улсын төмөр замын мэргэшсэн инженерингийн компани юм.

Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 304 дүгээр тогтоолоор компанийн хувьцааны 66 хувийг “Эрдэнэс Тавантолгой” ХК-д, 34 хувийг “Монголын төмөр зам” ТӨХК-д тус тус эзэмшүүлсэн нь компанийн үндсэн хөрөнгө, үйл ажиллагааны тогтвортой хөгжлийн нэгэн баталгаа болж байна.



ЭРХЭМ ЗОРИЛГО

Төмөр замын үйл ажиллагаа, төслийн удирдлагыг үндэсний эрх ашигт нийцсэн, чанар, аюулгүй байдлыг эрхэмлэсэн, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартаар хэрэгжүүлнэ.



АЛСЫН ХАРАА

Олон улсын түвшний төмөр замын үйлчилгээг эрхлэх чадавхтай, үндэсний хэмжээний тэргүүлэх байгууллага байх болно.



ҮНЭТ ЗҮЙЛС

- Удирдлагын манлайлал
- Мэргэшсэн, өндөр чадавхтай хамт олон
- Хэрэглэгчээ дээдлэх
- Үйлчилгээний чанар, аюулгүй байдал
- Тогтвортой хөгжил

МОНГОЛ УЛСЫН ТӨМӨР ЗАМЫН

Таних тэмдэг (Монгол)

- Одоогийн Төмөр зам
- Техникийн урьдчилсан зураг төсөл боловсруулагдсан төмөр замын чиглэлүүд
 - Тавантолгой-Сайншанд (435 км)
 - Сайншанд- Хөөт (430 км)
 - Хөөт-Чойбалсан (185 км)
 - Чойбалсан- Эрэнцав (210 км)
 - Хөөт-Бичигт (221 км)
 - Эрдэнэт- Овоот- Арцсуурь (770 км)
- Барилга байгууламж:
 - Тавантолгой-Гашуунсухайт (240 км)
 - Зүүнбаян-Цогтцэций (414 км)
- Урьдчилан тохируулсан (Хэвтээ тэнхлэгийн төмөр зам)
 - Хөөт- Нөмрөг (380 км)
- Богдхан төмөр замын төсөл:
 - Мандал-Багахангай (170 км)
- III үе шат:
 - Баруун чиглэлийн төмөр замын шугамыг цаашид ашигт малтмалын орд, бүс нутгийн хөгжлийн бодлогод тулгуурлан төлөвлөнө.

